

Монголын Үнэт Цаасны Бирж ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны 09 дугаар сарын 16-ны өдрийн
26/21 тоот тогтоолын хавсралт



ШИМТГЭЛ, ХУРААМЖИЙН ЖУРАМ

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ

ШИМТГЭЛ, ХУРААМЖИЙН ЖУРАМ

Нэг. Зорилго, хамрах хүрээ

1. Энэ журмаар “Монголын үнэт цаасны бирж” ХК (цаашид “Бирж” гэх)-ийн үйлчилгээний хураамж, шимтгэлтэй холбоотой харилцааг зохицуулна.
2. Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж болон Биржийн бусад дүрэм журам, гишүүд, хуулийн этгээдтэй байгуулсан холбогдох гэрээгээр зохицуулна.
3. Энэ журам нь хууль тогтоомж болон Биржийн дүрэм журмаар Биржийн гишүүд, үнэт цаас гаргагч болон бусад этгээдээс хураамж, шимтгэл авахаар зохицуулсан бүхий л харилцаанд хэрэглэгдэнэ.
4. Энэ журамд ашиглагдсан нэр томъёог Биржийн бусад холбогдох дүрэм, журамд тодорхойлсноор ойлгоно

Хоёр. Хураамж, шимтгэлийн төрөл

1. Биржийн үйлчилгээний хураамж нь дараах төрөлтэй байна:
 - A. Үндсэн үйл ажиллагаатай холбоотой хураамж, шимтгэл. Үүнд:
 - i. Гишүүнчлэлийн хураамж
 - ii. Бүртгэлийн хураамж
 - iii. Арилжааны шимтгэл
 - iv. Тооцооны шимтгэл
 - B. Бусад үйлчилгээтэй холбоотой хураамж, шимтгэл
 - i. Өргөдөл хянах үйлчилгээний хураамж
 - ii. Арилжааны түүх, мэдээ авах хураамж
 - iii. Системд нэвтрэх эрхийн төлбөр
 - iv. Хяналтын ажиллагааны хураамж
 - v. Бусад

Гишүүнчлэлийн хураамж

2. Гишүүнчлэлийн хураамжийг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гишүүнээр элсүүлэх шийдвэр нь гарсан өргөдөл гаргагч төлөх ба элсэлтийн ба жилийн гэсэн хоёр төрөлтэй байна.
3. Гишүүнчлэлийн элсэлтийн хураамжийг гишүүн Биржтэй Гишүүнчлэлийн гэрээ байгуулснаар төлөх ба жилийн хураамжийг Биржийн Гишүүнчлэлийн журмын дагуу гишүүн байх хугацаандаа жил тутам төлнө.

Бүртгэлийн хураамж

4. Бүртгэлийн хураамж нь Биржийн Бүртгэлийн журмын дагуу үнэт цаас

бүртгүүлэхээр өргөдөл гаргагч болон бүртгэлтэй үнэт цаас гаргагч төлөх ба Биржийн Бүртгэлийн журмын дагуу үнэт цаас бүртгүүлэх үед төлөх бүртгэлийн ажиллагааны хураамж болон бүртгэлтэй байх хугацааны жил тутмын, симбол өөрчлөх, бүртгэлд өөрчлөлт оруулах гэсэн төрлүүдтэй байна. Мөн үнэт цаасны бүртгэлийн хөгжлийн болон үндсэн талбараас хамаарч хэмжээг ялгаатай тогтооно.

5. Бүртгэлийн ажиллагааны хураамжийг үнэт цаас гаргагч нь татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн хөрөнгийн хэмжээнээс тогтоосон хувиар тооцон Биржтэй Бүртгэлийн гэрээ байгуулахаас өмнө төлсөн байна.
6. Жилийн хураамжийг бүртгэлтэй үнэт цаас гаргагч тухайн жилийн эхний сард багтаан төлөх бөгөөд Биржтэй тохиролцсон тохиолдолд 4 (дөрөв) хуваан улирал бүр төлж болно.
7. Хөгжлийн талбарт бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь үндсэн талбарт бүртгэгдэх тохиолдолд түүний төлсөн жилийн хураамжийг үлдсэн хугацаанд нь харгалзуулан тооцож, үндсэн талбарын жилийн хураамжид оролцуулан тооцож болно.
8. Бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь Биржид бүртгэлтэй үнэт цаасны симболыг өөрчлүүлэх тохиолдолд симбол өөрчлөх хураамжийг тухай бүр Биржид төлнө.
9. Бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь хувьцаа хуваах, нэгтгэх, нэмэлт хувьцаа гаргах гэх мэт бүртгэлтэй үнэт цаасанд өөрчлөлт оруулах тохиолдолд Бүртгэлд өөрчлөлт оруулах хураамжийг тухай бүр Биржид төлнө.

Арилжааны шимтгэл

10. Арилжааны шимтгэлийг Биржтэй гэрээ байгуулсан арилжааны гишүүд арилжаанд оролцсон үнийн дүнгээс хамаарч тогтоосон хувиар тооцон тухай бүр Биржид төлнө.
11. Арилжааны шимтгэл нь энгийн арилжааны шимтгэл, үүсмэл хэрэгслийн арилжааны хэрэгсэл гэсэн төрөлтэй байна.
12. Биржтэй зах зээлийн үүсгэх гэрээ байгуулсан арилжааны гишүүн нь зах зээл үүсгэх зорилгоор хийсэн хэлцлийн хувьд Бирж арилжааны шимтгэлийн хөнгөлөлттэй тариф тогтоож болно.

Тооцооны шимтгэл

13. Тооцооны шимтгэлийг Биржтэй гэрээ байгуулсан тооцооны гишүүд өөрсдийн тооцоо хийсэн дүнгээс тогтоосон хувиар тухай бүр Биржид төлнө.
14. Тооцооны шимтгэл нь энгийн арилжааны шимтгэл, үүсмэл хэрэгслийн арилжааны хэрэгсэл гэсэн төрөлтэй байна.

Бусад үйлчилгээний хураамж

15. Өргөдөл хянах үйлчилгээний хураамжийг Биржид гишүүнээр элсэх, үнэт цаас бүртгүүлэх зэрэг өргөдөл гаргах үед төлөх ба тус хураамж нь өргөдөл хэрхэн шийдвэрлэгдсэнээс үл хамаарч буцаан олгогдохгүй.
16. Арилжааны түүх, мэдээний хураамж нь арилжааны болон тооцооны гишүүн, эсвэл тэдгээрийн харилцагчийн хүсэлтээр Биржээс тэдэнд тодорхой хугацааны арилжааны түүх гарган өгөх үйлчилгээний хураамж юм.
17. Системд нэвтрэх эрхийн төлбөр нь Бирж арилжааны болон тооцооны гишүүнд Биржтэй холбогдох системийн нэвтрэх эрх олгох үйлчилгээний төлбөр байна.
18. Хяналтын ажиллагааны хураамж нь арилжааны болон тооцооны гишүүн болон үнэт цаас гаргагч Биржийн гаргасан аливаа шийдвэрийн талаар Биржийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд гомдол гарган хянан шийдвэрлүүлэхтэй холбоотой төлөх хураамж байна.
19. Биржийн үйл ажиллагаатай холбоотойгоор хэрэгжүүлэх бусад үйлчилгээний төлбөр, шимтгэл, хураамжийг тухай бүр Бирж тогтооно.

Гурав. Хураамж, шимтгэлийн хувь, хэмжээ

1. Хураамж, шимтгэлийн хувь, хэмжээг Биржийн Төлөөлөн Удирдах Зөвлөл тогтооно.
2. Эрх бүхий байгууллагаас хураамж, шимтгэлийн хувь, хэмжээний дээд хэмжээг тогтоосон бол Бирж тус дээд хэмжээний дотор хураамж, шимтгэлийн хувь, хэмжээг тогтооно.
3. Бирж хураамж, шимтгэлийн төлөх үүргийг баталгаажуулах зорилгоор хуульд заасны дагуу тодорхой хувиар алданги, торгууль тооцож болно. Энэ тохиолдолд энэ талаар гишүүд, хуулийн этгээдтэй байгуулах холбогдох гэрээнд тусгана.

Дөрөв. Хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшуулал

1. Биржийн шимтгэл, хураамжийг тодорхой хувиар хөнгөлөх, чөлөөлөх эсвэл зах зээлд оролцогчдод урамшуулал олгох тухай шийдвэрийг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөл, мөн ТУЗ-өөс олгогдсон эрхийн хэмжээнд Гүйцэтгэх захирал тухай бүр гаргаж болох бөгөөд ямар этгээдийг аль шимтгэл, хураамжаас хэдий хугацаанд ямар нөхцөлөөр хөнгөлж, чөлөөлж эсвэл урамшуулж буйг Биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол эсхүл Гүйцэтгэх захирлын тушаалд тодорхой заасан байна. Шаардлагатай тохиолдолд хөтөлбөр боловсруулж батлан, хэрэгжүүлж болно.

Тав. Биржээс үнэ төлбөргүй үзүүлэх үйлчилгээ

1. Бирж нь өөрийн арилжааны болон тооцооны гишүүдэд дараах үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэнэ. Үүнд:
 - i. Гишүүн ҮЦК нь өөрийн гишүүнчлэлтэй холбоотой зөвлөгөө, мэдээллийг

авах

- ii. Сар бүр нэгдсэн тайлан, мэдээ хүлээн авах
 - iii. Гишүүнчлэлтэй холбоотой лавлагаа, тодорхойлолт авах
 - iv. Гишүүнчлэлийн мэдээлэл тухай бүр шинэчлэх *(Гишүүнчлэлийн мэдээллээ тухай бүр шинэчлэн ирүүлээгүй тохиолдолд нэмэлт хураамж төлнө)*
2. Бирж нь бүртгэлтэй үнэт цаас гаргагчид дараах үйлчилгээг үнэ төлбөргүй хүргэнэ. Үүнд:
- i. Бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь Биржээс анх удаа симбол авах
 - ii. Биржтэй харилцах ажилтны сургалт 1 удаа
 - iii. Компанийн мэдээлэл оруулах, шинэчлэх *(Бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь мэдээллээ тухай бүр шинэчлэн ирүүлээгүй тохиолдолд нэмэлт хураамж төлнө.)*
 - iv. Бүртгэлтэй үнэт цаасны гаргагч нь өөрийн тогтмол хүлээх үүргийн талаарх зөвлөгөө, мэдээлэл авах
 - v. Сар бүр тайлан, мэдээ хүлээн авах
 - vi. Бүртгэлтэй үнэт цаасны гаргагч нь өөрийн мэдээллийн талаар лавлагаа, тодорхойлолт авах.

Гишүүнчлэлийн хураамж

Хураамжийн нэр		Хэмжээ	Давтамж
Өргөдөл хянах үйлчилгээний хураамж		500,000₮	
Элсэлтийн хураамж	Энгийн арилжааны гишүүн	8,000,000₮	1 удаа
	Үүсмэл хэрэгслийн арилжааны гишүүн	3,000,000₮	
	Тооцооны шууд гишүүн	5,000,000₮	
	Тооцооны ерөнхий гишүүн	10,000,000₮	
Жилийн хураамж	Арилжааны гишүүн	1,000,000₮	жилд 1 удаа
	Тооцооны гишүүн	2,000,000₮	
Арилжааны түүх, мэдээний хураамж		150,000₮	тухай бүр
Системд нэвтрэх эрхийн төлбөр	Энгийн арилжааны гишүүн	200,000₮	улиралд 1 удаа
	Үүсмэл хэрэгслийн арилжааны гишүүн	300,000₮	
	Тооцооны гишүүн	300,000₮	
Хяналтын ажиллагааны хураамж		500,000₮	тухай бүр

Бүртгэлийн хураамж

Хураамжийн нэр		Хэмжээ		Давтамж	Тайлбар
Өргөдөл хянах үйлчилгээний хураамж		1,500,000₮			-
Бүртгэлийн хураамж	Хувьцаа, варрант	0.1%	Үндсэн талбар 25,000,000₮ - 250,000,000₮ Хөгжлийн талбар – 10,000,000₮ - 100,000,000₮	1 удаа	Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүнгээс тооцно.
	Өрийн хэрэгсэл	0.1%			
	Сангийн нэгж эрх	0.5%			
	ХБҮЦ	0.1%			
Жилийн хураамж	Хувьцаа	10,000,000₮	Үндсэн талбар, I ангилал	жилд 1 удаа	-
		3,000,000₮	Үндсэн талбар, II ангилал		
		1,500,000₮	Хөгжлийн талбар		
	Сангийн нэгж эрх	0.1%			
Симбол өөрчлөх		500,000₮		тухай бүр	
Бүртгэлд өөрчлөлт оруулах		1,000,000₮			
Системд нэвтрэх эрх		200,000₮		жилээр	
Хяналтын ажиллагааны хураамж		500,000₮		тухай бүр	

Арилжааны шимтгэл

Шимтгэл			Хэмжээ	
Энгийн арилжааны шимтгэл	Хувьцаа, сан, варрант	100 сая хүртэл	0.4%	
		100 саяас 1 тэрбум хүртэл	0.3%	
		1 тэрбумаас дээш	0.2%	
		Зах зээл үүсгэгч	0.1%	
	Өрийн хэрэгсэл + ХБҮЦ	Анхдагч, авах тал	0.03%	
		Анхдагч, зарах тал	0.15%	
		Хоёрдогч, авах, зарах тал тус бүр	0.03%	
	Багцын арилжаа			0.1%
	Кросс хэлцэл	100 сая хүртэл	0.5%	
		100 саяас 1 тэрбум хүртэл	0.4%	
1 тэрбумаас дээш		0.3%		
Үүсмэл хэрэгслийн арилжааны шимтгэл	Валютын фьючерс	Авах, зарах тал тус бүр	50₮	
	Бусад	Авах, зарах тал тус бүр	250₮	
Захиалгын өөрчлөлт	Захиалга цуцлах		50,000₮	
	Захиалга шилжүүлэх (шилжүүлсэн талаас)		2,500₮	

Тооцооны шимтгэл

Шимтгэл			Хэмжээ
Энгийн арилжааны тооцооны шимтгэл	Хувьцаа, сан, варрант	авах, зарах тал бүрээс, 1 тэрбумаас доош	0.18%
		авах, зарах тал бүрээс, 1 тэрбумаас дээш	0.15%
	Бонд, ХБҮЦ	авах, зарах талаас	0.008%
Үүсмэл хэрэгслийн тооцооны шимтгэл	Позиц нээх	гэрээний тал бүрээс	100₮
	Позиц хаах	гэрээний тал бүрээс	150₮
	Бодит хүргэлтээр позиц хаах	гэрээний тал бүрээс	0.15%
	Позиц шилжүүлсэн төлбөр	шилжүүлсэн талаас	0.2%
Төлбөр төлөгдөөгүй тохиолдолд авах хураамж	Дефолт болсон гишүүний хураамж	Төлөгдөөгүй үнийн дүнгээс	1.0%
	Алданги (хоног тутам)	Төлөгдөөгүй үнийн дүнгээс	0.3%